*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын*
*даргын 2023 оны 98 дугаар тушаалын*
*6 дугаар хавсралт*

НИЙГМИЙН БОДЛОГЫН ХЭЛТЭСИЙН ХҮҮХЭД, ГЭР БҮЛ, ЖЕНДЭРИЙН БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН ЭРДЭНЭ-ОЧИРЫН ХОРОЛСҮРЭНГИЙН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлт ийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| Зорилт 1. Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгаалал, жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбарын хууль тогтоомж, бодлого стратеги, тогтоол шийдвэр, үндэсний болон орон нутгийн дэд хөтөлбөрүүдийг орон нутагт хэрэгжүүлэх, зохицуулах, үр дүнг үнэлж тайлагнана. | | | | | | | |
| 1. | Хүүхэд, гэр бүлийн салбар, жендэрийн асуудлаар бодлогын баримт бичгийн орон нутагт хамааралтай зорилт, заалтын хэрэгжилтийн мэдээ тайланг хугацаанд нь гаргаж тайлагнах | - тайлан мэдээний тоо<br>- хугацаандаа тайлагнасан эсэх | 23 | 13 | Алсын хараа 2050 Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол улсыг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, холбогдох хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн орон нутагт хамаарал бүхий хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгаалал, жендэрийн асуудлаар зорилт, арга хэмжээний хэрэгжилт, биелэлт, үр дүнг зохих хугацаанд тайлагнан, холбогдох хэлтэс, албан тушаалтанд хүргүүлэн ажиллаж байна. “Хүүхэд хамгааллын бодлого” (2015-2024)-ийн хэрэгжилт дуусч байгаатай холбогдуулан тайланг нэгтгэж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлж, биелэлтийг 80.1 хувьтай буюу “тодорхой үр дүнд хүрсэн” хэмээн үнэлж, хаагаад байна. | 2025.01 сараас 2025.06 сар | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Жендэрийн салбар хорооны 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 2025 оны 01 дүгээр сард Жендэрийн үндэсний хороо болон аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнаж, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар 84.3 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн. | | |
| 2. | Монгол Улсын хөгжлийн бодлого, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын жилийн хөгжлийн төлөвлөгөөний орон нутагт хамааралтай хүүхэд, гэр бүлийн салбар, жендэрийн асуудлаар зорилт, арга хэмжээний хэрэгжилт, зохион байгуулалтыг ханган, биелэлт, үр дүнг тайлагнаж мэдээллэх | - тайлан мэдээний тоо<br>- хугацаан даа тайлагна сан эсэх | 4 | 3 | Алсын хараа 2050 Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол улсыг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, холбогдох хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн орон нутагт хамаарал бүхий хүүхэд, гэр бүл, жендэрийн асуудлаар зорилт, арга хэмжээний хэрэгжилт, биелэлт, үр дүнг зохих хугацаанд тайлагнан, холбогдох хэлтэс, албан тушаалтанд хүргүүлэн ажиллаж байна. | 2025.01 сараас 2025.06 сар | 100 |
| 3. | Хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамж, Сайдын тушаал, Засгийн газрын хуралдаан, Ерөнхий сайд, ИТХурал, Засаг даргаас өгсөн орон нутагт хамааралтай хүүхэд, гэр бүлийн салбар, жендэрийн асуудалтай холбоотой үүрэг даалгаврыг биелүүлэх, ажлыг зохион байгуулж, биелэлт үр дүнг тайлагнах | - тайлан мэдээний тоо<br>- Хуга цаан даа тайлагна сан эсэх | 13 | 6 | Хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамж, Сайдын тушаал, Засгийн газрын хуралдаан, Ерөнхий сайд, ИТХурал, Засаг даргаас өгсөн орон нутагт хамааралтай хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгаалал, жендэрийн салбарын арга хэмжээний биелэлт, хэрэгжилтийн үр дүнг тайлагнаж, дээрх салбартай холбоотой үүрэг даалгаврыг биелүүлэх, хэрэгжилтийг хангах хүрээнд аймгийн Засаг даргаас сум, байгууллага, агентлагийн дарга нарт 6 удаа чиглэл, албан бичиг хүргүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлт үр дүнг хянаж, тайлан мэдээг авч байна. | 2025.01 сараас 2025.06 сар | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4. | Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд болон аймгийн Засаг даргын хооронд орон нутагт хүүхэд, гэр бүлийн салбарт хамтран ажиллах гэрээний хэрэгжилтийг тайлагнах | - тайлан мэдээний тоо<br>- хугацаандаа тайлагнасан эсэх | 2 | 1 | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд бөгөөд төсвийн ерөнхийлөн захирагч болон аймгийн Засаг даргын хооронд төрийн зарим чиг үүргийг 2025 онд орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний биелэлт хагас жилийн тайланг хугацаанд нь тайлагнаж, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлээд байна. | 2025.01 сараас 2025.06 сар | 100 |
| 5. | Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, жилийн хөгжлийн төлөвлөгөө, хүүхэд, гэр бүлийн салбарын бодлого стратегийг хэрэгжүүлэх, биелэлт үр дүнг тайлагнах | - тайлан мэдээний тоо<br>- хугацаандаа тайлагнасан эсэх | 4 | 2 | Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгасан хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгаалал, жендэрийн салбарын арга хэмжээний биелэлт, хэрэгжилтийн үр дүнг тайлагнаж, аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээний хэлтэс үр дүнг үнэлж, Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж байна. | 2025.01 сараас 2025.06 сар | 100 |
| 6. | “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар дундын стратеги төлөвлөгөө 2025”-г хэрэгжүүлэх, биелэлт, үр дүнг тайлагнах | - тайлан мэдээний тоо<br>- хугацаандаа тайлагнасан эсэх | 5 | | Аймгийн жендэрийн салбар хорооны 2024 оны үйл ажиллагааны тайланг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн Хуралдаанаар хэлэлцүүлж, 84,3 хувийн биелэлттэй дүгнэлээ. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар дундын стратеги төлөвлөгөөний дагуу салбар хорооны 2025 оны төлөвлөгөөг батлуулж, сум, агентлаг, байгууллагуудад хүргүүлж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Жендэрийн үндэсний хорооноос жил бүр үндэсний хэмжээнд зохион байгуулдаг “ХАРИЛЦАН ХҮНДЭТГЭЭ” аянд 9 сум, 12 байгууллага идэвхтэй оролцож, аяны хүрээнд дээрх сум, байгууллагууд сургалт нөлөөллийн ажил зохион байгуулж, иргэдийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүллээ. | 2025.01 сараас 2025.06 сар | 100 |
| 7. | “Халуун ам бүл” төслийн бичиг баримтыг боловсруулж, аймгийн Засаг даргын зөвлөл, ИТХ-ын хороо, зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, батлуулах | - хэрэгжилтийн хувь | 70.0 | 15.0 | Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд “Халуун ам бүл” төслийг боловсруулж, аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, иргэдийн | 2025.01 | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлж батлуулахаар бэлтгэж байна. | сараас 2025.06 сар | 100 |
| 8. | “Хайрлагдсан хүүхэд” төслийн бичиг баримтыг боловсруулж, аймгийн Засаг даргын зөвлөл, ИТХ-ын хороо, зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, батлуулах | - | хэрэг жилтийн хувь | 70.0 | 15.0 | Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд “Хайрлагдсан хүүхэд” төслийг боловсруулж, аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлж батлуулахаар бэлтгэж байна. | 2025.01 сараас 2025.06 сар | 100 |
| Зорилт 2. Аймгийн хүүхэд, гэр бүлийн салбарын хөгжлийн стратегийг төлөвлөх, хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад чиглэсэн бодлого зохицуулалт, мэргэжил, арга зүйн дэмжлэгээр хангах, хяналт, шинжилгээ хийх | | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ 2.1.<br>Аймгийн хүүхэд, гэр бүлийн салбар, жендэрийн хөгжлийн стратегийг төлөвлөх | - | | | | Хэрэгжилт тооцох болоогүй. | 2025 оны 12 сар | |
| 2. | Арга хэмжээ 2.2.<br>Аймгийн Засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын салбар, жендэрийн эрх тэгш байдлыг хангах хөгжлийн стратегийг боловсруулах, төлөвлөх | - | боловс руулсан баримт бичгийн тоо | | | Хэрэгжилт тооцох болоогүй. | 2025 оны 12 сар | |
| 3. | Арга хэмжээ 2.3.<br>Аймгийн 2025 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөний хүүхэд, гэр бүлийн салбар, жендэрийн хөгжлийн зорилт, арга хэмжээг боловсруулах, төлөвлөх | - | боловс руулсан баримт бичгийн тоо | | | Хэрэгжилт тооцох болоогүй. | 2025 оны 12 сар | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4. | Арга хэмжээ 2.4.<br>Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад чиглэсэн бодлого зохицуулалт, мэргэжил, арга зүйн дэмжлэгээр хангах, хяналт, шинжилгээ хийх | - Мэргэжил арга зүйн дэмжлэг ээр хангаж, хяналт, шинжил гээ хийсэн үйл ажиллаг ааны тоо<br>- Хамрагд сан байгуул лага, хүний тоо | 4 | 3 | Бүрд, Баян-Өндөр суманд ажиллаж, төрийн аллбан хаагчдад сургалт зохион байгуулахын зэрэгцээ сумдын хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад чиглэсэн бодлого зохицуулалт, хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичгийн хэрэгжилттэй танилцаж, мэргэжил, арга зүйн зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн. Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын мэргэжилтнүүд болон сумдын нийгмийн бодлогын мэргэжилтнүүд, хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтнуудад арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлж хяналт тавин ажиллаж байна. | 2025.01 сараас 2025. 06 сар | 90.0 |
| Зорилт 3. "Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, засгийн газрын бодлого шийдвэр, хэтийн болон дунд хугацааны бодлого, хөтөлбөрийг сурталчлан таниулах, хэрэгжүүлэх ажлыг төлөвлөх, зохион байгуулах, тайлагнах" зорилтын хүрээнд | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ 3.1.<br>Жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаар авч хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, явцыг аймгийн ИТХТэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлэх, хуулийн хэрэгжилтийг хангах, арга зүйн зөвлөмжийг сум, байгууллагуудад түгээх | - зөвлөмж мэдээл лийн тоо | 5 | 6 | Салбар хорооноос 2024 онд жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаар авч хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан, 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлж, Жендэрийн үндэсний хороонд хүргүүлсэн.<br>Жендэрийн салбар хорооны 2025 оны төлөвлөгөөг сум, байгууллагуудад хүргүүлж, хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.<br>Жендэрийн үндэсний хорооноос авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, явцыг орон нутагт түгээж, жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийг хангах, салбар хорооны | 2025.01 сараас 2025.06 сар | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | ажлыг эрчимжүүлэх зорилгоор орон нутаг, байгууллага аж ахуйн нэгжүүдэд арга зүйн зөвлөмж өгч, сургалт нөлөөллийн ажил давтамжтай зохион байгуулж байна. | | |
| 2. | Арга хэмжээ 3.2.<br>Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар дундын стратеги төлөвлөгөөний хэрэгжилт, Жендэрийн салбар хорооны 2024 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллах | - хэрэгжилтийн хувь | 83.6 | 70.0 | Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар дундын стратеги төлөвлөгөөний хэрэгжилт, Жендэрийн салбар хорооны 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллах хүрээнд жендэрийн ялгаварлан гадуурхалтаас татгалзъя, жендэр ба хөгжил, жендэрт суурилсан хүчирхийлэл түүнээс урьдчилан сэргийлэх нь, ажлын байрны дарамт, ажлын байран дахь бэлгийн дарамтаас сэргийлэх нь зэрэг сэдвээр 9 сум, 16 байгууллагат сургалт зохион байгуулж, 320 гаруй ажилтан, албан хаагч хамрагдаж мэдээлэл авлаа. 2025 оны эхний улиралд үндэсний хэмжээнд зохион байгуулсан “Харилцан хүндэтгэе” аян, жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аяны хүрээнд 10 гаруй постер, видео, шторк мэдээллийг орон нутгийн цахим хуудас болон олон дагагчтай группэд түгээж, 8.0 мянга гаруй хандалт авсан байна. Жендэрийн салбар хорооны 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. | 2025.01 сараас 2025.06 сар | 100 |
| 3. | Арга хэмжээ 3.3.<br>Жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, нөлөөллийн арга хэмжээнд орон нутгийн иргэд, олон нийт, залуучууд, зорилтот бүлгийн оролцоог ханган, хөгжлийн бэрхшээлтэй болон эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн онцлог хэрэгцээнд зориулсан | - сургалт, нөлөөллийн ажлын тоо | 8 | 8 | Үндэсний хэмжээнд зохион байгуулагдсан "Харилцан хүндэтгэе" аянд нэгдэж, салбар хорооноос орон нутгийн байгууллага, сумдыг уриалан, үйл ажиллагааг идэвхжүүлж, оролцлоо. Аймгийн хэмжээнд төрийн 36 байгууллага, 13 аж ахуйн нэгж, 16 сум аянд нэгдэж буйгаа илэрхийлж, аяны нэр, уриа бүхий постер, хүрээнд зургаа авхуулж, уриалан олон нийтийн сүлжээнд байршуулж, сургалт нөлөөллийн ажил зохион | 2025.01 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | сургалт, нөлөөлийн арга хэмжээг зохион байгуулах | | | | байгуулж оролцлоо. Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аяны хүрээнд хүчирхийллийг таслан зогсоох, түүнээс урьдчилан сэргийлэхэд байгууллага хамт олноороо цагаан туузтаны хөдөлгөөнд нэгдэж, сум, байгууллага, аж ахуйн нэгжүүдэд аяны удирдамж, танилцуулгыг хүргэж, нэгдэн ажиллахад зөвлөгөө дэмжлэг үзүүлж, мэдээлэл түгээн ажиллалаа. | сараас 2025.06 сар | |
| Зорилт 4. Аймгийн Засаг даргын дэргэдэх орон нутгийн салбар зөвлөлүүдийн үйл ажиллагааг зохион байгуулах | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ 4.1. Жендэрийн салбар хорооны хурлыг зохион байгуулж, төлөвлөгөө боловсруулан, хэрэгжүүлж, биелэлт үр дүнг тайлагнана. | - Хурлын тоо<br>- Биелэлт | 1<br>83.3 | 1 | Жендэрийн салбар хорооны хурлыг 6 дугаар сард хуралдуулахаар төлөвлөгөөнд тусгасан. | 2025.01 сараас 2025.06 сар | |
| 2. | Арга хэмжээ 4.2. Аймгийн Хүүхдийн төлөө зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлж, төлөвлөгөөний биелэлт үр дүнг тайлагнана. | - тайлан, мэдээний тоо | 1 | 1 | Аймгийн Хүүхдийн төлөө зөвлөл 5 дугаар сард хуралдаж, хүүхдийн зөвлөлийн ажиллах дүрмийг хэлэлцэж, төлөвлөгөөг баталлаа. | 2025.01 сараас 2025.06 сар | 100 |
| 3. | Арга хэмжээ 4.3. Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны ажлыг эрчимжүүлж, төлөвлөгөөний биелэлт үр дүнг тайлагнана. | - Хэрэгжилтийн хувь | | | Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо төлөвлөгөөний дагуу ажиллаж, бүртгэлтэй, үйлчилгээ авч байгаа 6 хүүхдийн гэр бүлд нөхцөл байдлын болон хүүхдийн эрсдлийн үнэлгээг хийж, тэдний эцэг эх, асран хамгаалагчдад зөвлөгөө мэдээлэл өгч, тухайн хүүхдүүдийг харьяалах багийн хамтарсан багт албан бичгийн хамт хүлээлгэн өгөөд байна. | 2025.01 сараас 2025.06 сар | 90.0 |
| 4. | | | | 60.0 хувь | "Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих" салбар дундын хамтын ажиллагааг орон нутгийн түвшинд уялдуулан зохицуулах, хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар хангах, дэмжлэг үзүүлэх, үнэлгээ, дүгнэлт өгөх чиг үүрэг | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Арга хэмжээ 4.4.<br>Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих салбар зөвлөлийн бүрэлдэхүүний хурлыг зохион байгуулж, төлөвлөгөө боловсруулан, хэрэгжүүлж, биелэлт үр дүнг тайлагнана. | - Хэрэгжилтийн хувь | | | бүхий "Орон тооны бус орон нутгийн зөвлөл"-ийн төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Орон нутгийн түвшинд бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих талаарх бодлого, зорилтуудыг хэрэгжүүлэх төлөвлөлт хийх арга зүй олгох, бага насны хүүхдэд чиглэсэн цогц үйлчилгээнд хүүхэд нэг бүрийн хамруулах сайн туршлагыг түгээх болон хүүхдийн эрүүл мэнд, хоол тэжээл, асаргаа халамж, хамгаалал, хөгжил боловсролын талаарх орчин үеийн онол, чиг хандлага, арга зүйн мэдлэг, чадвар олгох сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулж, салбар бүрийн төлөөлөл 14 хүн оролцсон. | 2025.01 сараас 2025.06 сар | 90.0 |

**Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт**

| Д/д | Үүрэг даалгавар | Үүрэг даалгавар өгсөн удирдах албан тушаалтан | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрсэн түвшин биелэлт | Эхлэх хугацаа | Дуусах хугацаа |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 1<br><br>Хүүхэд, гэр бүл, жендэрийн асуудлаар холбогдох байгууллагуудаас сар бүрийн ажлын жагсаалт авч, удирдлагыг тогтмол мэдээллээр ханган ажиллах | | - Сарын ажлын биелэлт | 100 хувь | Хүүхэд, гэр бүл, жендэрийн асуудлаар холбогдох агентлагуудаас сар бүрийн ажлын жагсаалт авч, нэгтгэн өгч байна. Салбарын агентлагтай холбоотой ажил, асуудлыг хэлтэсийн даргат мэдээллэж, мэдээллээр хангаж байна. | 2025.01 сар | 2025.06 сар |
| 2. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 2<br>Хүүхэд, гэр бүл, жендэрийн асуудлаар аймгийн Засаг даргын шийдвэрийн төслийг цаг тухай бүрт боловсруулах | Аймгийн Засаг дарга | - гаргасан захирамжийн төсөл | 15 | Салбарын агентлагтай холбоотой аймгийн Засаг даргын 9 захирамжийн төсөл, 6 албан бичиг, чиглэл төлөвлөж, | 2025.01 сар | 2025.06 сар |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | албан бичгийн тоо | | холбогдох яам, агентлаг, сум, байгууллагуудад хүргүүлээд байна. | | |
| 3. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 3 Аймгийн Засаг даргаас сумдын Засаг даргатай байгуулах гэрээнд салбарын холбогдолтой заалт тусгаж төлөвлөх | | - | Санал, заалтын тоо | | Аймгийн Засаг даргаас сумдын Засаг даргатай байгуулах гэрээнд салбарын холбогдолтой заавал тусгах шаардлагатай заалт, арга хэмжээг агентлагтай зөвшилцөж, санал оруулсан. | 2025.01 сар | 2025.06 сар |
| 4. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 4. Салбарын холбогдох асуудлаар албан бичиг боловсруулж хүргүүлэх | | - | Албан бичгийн тоо | | "Хүүхэд хамгааллын бодлого"-ын хэрэгжилт төрийн аудитаар шалгагдсантай холбогдуулан аймгийн Төрийн аудитын газарт холбогдох 2 албан бичиг, мэдэгдэл хүргүүлсэн. Хүний эрхийг хангах, жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр сум, байгууллагуудад "Дархан бэр", ""Уран бэр" арга хэмжээ зохион байгуулахгүй байх мэдэгдэл хүргүүлсэн. | 2025.01 сар | 2025.06 сар |
| 5. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 5. Тамгын газрын даргын болон хэлтэсийн даргын өгсөн үүрэг даалгавар, ажлыг гүйцэтгэх | ЗДТГ-ын дарга, НБХ-ийн дарга | - | Гүйцэтгэсэн үүрэг даалгаврын биелэлт хувь | | Байгууллагын удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь гүйцэтгэж, аймгийн "Төрийн албаны манлайлал" хангайн бүсийн зөвлөгөөний бэлтгэл ажлыг хангахад оролцож, "Төрийн албан хаагч эмэгтэйчүүдийн карьер хөгжлийг дэмжих, | 2025.01 сар | 2025.06 сар |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | төрийн албан дахь удирдах түвшний жендер" сургалт, хэлэлцүүлэгт оролцож, тайлан мэдээг бичиж, Төрийн албаны зөвлөлд явууллаа. Засаг даргын Тамгын газрын даргын 2 тушаалын төсөл боловсруулж, хэлтсийн даргаас байгууллагуудад хүргүүлсэн 3 албан бичгийг төлөвлөж ажиллалаа. | | |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | Арга хэмжээ 2.1.<br>Төрийн албаны зөвлөл болон бусад мэргэжлийн чиг үүргийн хүрээнд зохион байгуулагдаж буй сургалтад хамрагдаж, мэдлэг чадвараа дээшлүүлэх | Сургалт-ын тоо<br><br>- сургалтын тоо | 8 | 10 | 2025 оны эхний хагас жилд хүүхэд гэр бүлийн хөгжил, хамгааллын чиглэлээр 2 удаагийн цахим сургалт, 3 хэлэлцүүлэгт оролцож, мэдээлэл авч, санал дүгнэлтээ уламжилсан. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр 2 удаагийн цахим сургалт, 1 хэлэлцүүлэгт оролцсон. Үндэсний хэмжээнд зохион байгуулагдсан "Жендэрийн эрх тэгш байдал ба уур амьсгалын өөрчлөлт" олон улсын хуралд оролцож, мэдлэг ойлголтоо нэмэгдүүлсэн. Удирдлагын | 2025.01 сар<br>2025.06 сар | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | академиас зохион байгуулсан “Сэтгэлгээний өөрчлөлт” сургагч багш бэлтгэх сургалтад хамрагдаж, сертификат авсан. | | |
| 2. | Арга хэмжээ 2.2. Шинээр батлагдан гарч буй холбогдох хууль, тогтоомж, дүрэм, журам бусад эрх зүйн актуудыг унших, судлах | уншиж судалсан эсэх | 2 | 3 | Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулга, Төрийн албан хаагчийн ёс зүйн байдлын тухай хуулийг уншиж танилцан, жендэрийн мэдрэмжтэй ажлын байрны тодорхойлолтыг уншиж мэдлэг ойлголт авлаа. | 2025.01 сар 2025.06 сар | 100 |
| 3. | Арга хэмжээ 2.3. Англи хэлний унших, бичих чадвараа нэмэгдүүлэх | уншиж судалсан эсэх | - | Мэдлэг чадвар сайжирсан байна. | Англи хэлний унших, ойлгох чадвараа сайжруулахын тулд “Step to step” дунд шатны цахим сургалтад хамрагдаж байна. | 2025.01 сар 2025.06 сар | 100 |
| 4. | Арга хэмжээ 2.4. Монгол бичгээр компьютерийн хэрэглээний программд бичиж сурах | Хэрэгжүүлсэн арга хэмжээ | - | Мэдлэг чадвар сайжирсан байна. | Монгол бичгээр хурдан бичих, хурлын тэмдэглэл хөтлөж хэвшихэд суралцахын зэрэгцээ монгол бичгээр компьютерийн хэрэглээний программд бичиж сурах дадлагыг тогтмол хийж байна. | 2025.01 сар 2025.06 сар | 100 |

ТАЙЛАН ГАРГАСАН:
ХҮҮХЭД, ГЭР БҮЛ, ЖЕНДЭРИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН ................................ (Э.ХОРОЛСҮРЭН) 2025.06.13.